



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.11.15 № 01/2456

танай _____-ны № _____-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД**

Тодруулга хүргүүлэх тухай

Тус компаниас 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зарласан ЭТТХК/20240102322 дугаартай Хүнд даацын техник, тоног төхөөрөмжийн дугуй нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг тендерт оролцогчоос гаргасны дагуу Монополын эсрэг газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж, 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1603 дугаартай "Тендерийн баримт бичиг хянасан тухай" ирүүлсэн албан бичгийн дагуу тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулсныг хавсралтаар хүргүүлэв.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 24.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.
ТШЗ 26.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут Тендер нээх газрын хаяг: "Эрдэнэс Таван толгой" ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, 5-р давхар, 502 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс

- 1 дүгээр хавсралтаар тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.
- 2 дугаар хавсралтаар 1 дүгээр багцын шинэчилсэн техникийн тодорхойлолтыг хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралтхуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124044532



Хавсралт 1

Тодруулгын хариу

Тендерийн нэр	Хүнд даацын техник, тоног төхөөрөмжийн дугуй нийлүүлэгчийг сонгох
Тендерийн дугаар	ЭТТХК/20240102322
Тендер зарласан огноо	2024 оны 09 дүгээр сарын 10
Тендер нээх огноо	2024 оны 11 дүгээр сарын 28
Тодруулга №1	
Багц 1: Автосамосвалын дугуй /33.00R51/ техникийн тодорхойлолтын техникийн үзүүлэлт хэсэгт хийн даралтыг 7бар-аас ихгүй гэсэн байна. Хүнд даацын дугуйн стандарт буюу хамгийн бага хийн даралт ихэвчлэн 7бар байдаг. Техникийн тодорхойлолт дээр багагүй гэдгийг ихгүй гэж андуурч бичсэн бол залруулж өгнө үү?	
Тодруулга №2	
Багц 1-рт байгаа 33.00R51 дугуйны бат бөхийн индекс/давхрага хийцийн төрөл/-ийг 2 одоос дээш, даацыг 41250 кг-с багагүй гэж заасан байгаа нь хоорондоо зөрчилтэй үзүүлэлт байна. 2 одтой дугуйны даац 38,750кг, 3 одтой дугуйных 41,250кг байдаг. Тэгэхээр шууд 2 одтой дугуйгаар оролцох боломжгүй юм байна. Хэрвээ 2 одоос дээш байх гэж шаардаж байгаа бол 2 одтой дугуйгаар оролцох боломжтой юм бол даацыг дүйцүүлэн 38,750 кг-с багагүй гэж заах ёстой юм. Эсвэл 41,250кг-с багагүй гэж шаардаж байгаа бол 2 одтой биш 3 одтой дугуй байна гэж шаардах ёстой болж байгаа тул нягталж үзээд хариу өгнө үү.	
Тодруулга №3	
Манай компани ЭТТХК/20240102322 дугаартай 5 багц Хүнд даацын техник, тоног төхөөрөмжийн дугуй тендерт оролцож байгаа бөгөөд тус тендер шалгаруулалтын техникийн тодорхойлолтод заагдсан үзүүлэлтүүдээс дараах тодруулгыг авах шаардлагатай байна. Үүнд: 1. Багц:1-т заасан 33.00R51 размерын дугуйны техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтүүд нь өмнө нь 2022 онд зарлагдсан тендерийн шаардлагаас өөрчлөлт орж чухал үзүүлэлтүүдийн (хээний гүн, ТКРН, статик ачааллын радиус, жин, диаметр, өргөн) тоон утга нэмэгдэж зөвхөн Michelin брэндийн XDR3 C4 загварын хээтэй дугуйны үзүүлэлтээр тохируулж оруулсан байгаа нь бусад брэндийн дугуйнуудын үзүүлэлтэд тохирохгүй /тоон утга хүрэхгүй/, нэг брэндийн дугуйны үзүүлэлттэй таарсан байдлаар давуу тал олгож бусад өрсөлдөгчийг хязгаарласан гэж үзэж байгаа тул нягталж өгнө үү.	
1 дүгээр багцын техникийн тодорхойлолт хавсралтаар шинэчлэн хүргүүлж байна.	

Тодруулга №4	
Тодруулга	Хариу
Багц:2 35/65R33 размерын дугуйны өргөн 930мм-ээс ихгүй гэж заасан байгаа нь энэ үзүүлэлтээс бага хэмжээтэй дугуйнууд болно гэж үзэж болох уу? Жишээ нь бусад брэндийн дугуйны өргөн (890-930мм) хүртэлх хэмжээтэй байгаа.	35/65R33 размерын дугуйн өргөн нь 930мм-ээс их байж болохгүй.
Тодруулга №5	
Тодруулга	Хариу
Багц:3-т 20.5R25 размерын дугуйны өргөн 530-565мм гэсэн тоон утга нь мөн адил Michelin брэндийн XLD D2 төрлийн хээтэй дугуйны үзүүлэлтийг оруулсан байгаа нь бусад төрлийн брэндийн дугуйнуудын өргөний хэмжээ 530мм хүрэхгүй дутаж байгаа тул нэг брэндийн дугуйны үзүүлэлттэй таарсан байдлаар давуу тал олгож бусад өрсөлдөгчийг хязгаарласан гэж үзэж байгаа тул нягталж өгнө үү.	20.5R25 размерын дугуйны өргөн 530-565мм хооронд байх шаардлагатай бөгөөд дээрх хэмжээтэй дугуйн төрөл нь нэг брэндийн дугуй байдаггүй тул өрсөлдөөнийг хязгаарлаагүй болно.

**Багц 1: АВТОСАМОСВАЛЫН ДУГУЙ /33.00R51/
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Ерөнхий шаардлага:

№	Төрөл	Үзүүлэлт	Хэмжих, нэгж	Онцгой шаардлага	Тайлбар
1	Төрөл	Off The Road эсхүл түүнтэй дүйцэх			
2	Загвар	Радиал дугуй байна			
3	Техникийн үзүүлэлт	Дугуйн хээний төрөл		E-4	Уул уурхайн зориулалттай Чулуулаг гадаргуйн
		Ашиглалтын төрөл	код	3A	Зүсэлт, халалтад Тэсвэртэй байх
		Хэмжээ		33.00R51	-
		Давхрага хийцийн төрөл		**	2 ба түүнээс дээш одтой байх
		Хээний гүн	мм	84	Багагүй
		Дугуйн ТКРН		825	Багагүй
		Ашиглаж болох хурд	км/цаг	50	Багагүй
		Хийн стандарт даралт	bar/psi	7/102	-
		Дугуйн дээрх зөвшөөрөгдөх даац	кг	38750	7/102(bar,psi)-аар хийлэхэд дугуйн дээрх зөвшөөрөгдөх хамгийн бага даац, түүнээс дээш байх
		Обудны хэмжээ	Инч	24.00/5.0	-
		Статик ачаалалтай радиус	мм	1356-1376	Хооронд
		Диаметр	мм	3032-3063	Хооронд
Өргөн	мм	895-945	Хооронд		
2023 байх оноос хойш үйлдвэрлэсэн байх					
4	Тусгай шаардлага	Орчны температур C ⁰	Дээд	+38	Тухайн бүс нутгийн хамгийн дээд, доод утга
5			доод	-40	
6		Чанарын сертификат	1ш	Англи хэл	-
7		Техникийн паспорт	1ш	Англи хэл	-
8		Гарал үүслийн сертификат	1ш	Англи хэл	-
9	Баталгаа хугацаа	6000 мото/цагаас багагүй байна.			
10	Тоо хэмжээ	74 ширхэг			
11	Нэмэлт	Тухайн дугуй тус бүрт HALTEC брэндтэй дүйцэхүйц -40 өөс 180с ашиглахад тохиромжтой чанарын шаардлага хангасан O-ring дагалдуулж олгоно.			